



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Биеийн тамир спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/155/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Булган аймаг	Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
2023 он	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
	Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.15 № 69
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.БАТХИШИГ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Булган аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Булган аймгийн Биеийн тамир, спортын газар нь 1 хөтөлбөр, 5 арга хэмжээний хүрээнд нийт 1,039,749.6 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,037,424.6 мянган төгрөгийг зарцуулж хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 99.7 хувьтай байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Булган аймгийн Биеийн тамир спортын газрын шууд захирагч нь 2022 онд аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 39 арга

006020073

хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 93.7 хувийн биелэлтэйгээр тайлагнасан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	84,683,624.00	52,930,110.00
35	БАРАА МАТЕРИАЛ	84,683,624.00	52,930,110.00
351	Түүхий эд материал	6,378,464.00	5,778,800.00
35110	Тусгай зориулалттай материал	3,960,000.00	3,960,000.00
35130	Эм боох материал	2,418,464.00	1,818,800.00
354	Хангамжийн материал	78,305,160.00	47,151,310.00
35410	Бичиг хэргийн материал	8,326,710.00	3,346,510.00
35420	Аж ахуйн материал	64,204,450.00	38,320,800.00
35450	Барилгын засварын материал	5,774,000.00	5,484,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,270,395,822.79	6,183,489,078.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,270,395,822.79	6,183,489,078.64
392	Биет хөрөнгө	6,159,540,522.79	6,072,971,278.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,468,281,188.68	6,468,225,748.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(475,627,553.89)	(594,260,204.89)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,600,000.00	73,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,039,999.93)	(22,399,999.89)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,871,279.00	119,684,843.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,683,101.19)	(45,776,988.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,208,254.38	53,805,924.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,033,216.26)	(25,870,335.07)
39209	Зам, гүүрийн байгууламж	45,749,561.20	45,749,561.20
39214	Бусад үндсэн хөрөнгө	240,226.00	240,226.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(66,115.20)	(67,496.52)
39217	Ном	40,000.00	40,000.00
393	Биет бус хөрөнгө	110,855,300.00	110,517,800.00
39301	Программ хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(337,500.00)	(675,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	109,842,800.00	109,842,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,355,079,446.79	6,236,419,188.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,000.00	-
413	Өглөг	15,000.00	-
4136	Бусад өглөг	15,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	15,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,573,487,678.79	4,454,842,420.64
51	Засгийн газрын хувь оролцоо	4,573,487,678.79	4,454,842,420.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,615,871,536.08	1,615,871,536.08
51101	Өмч: - төрийн	1,615,871,536.08	1,615,871,536.08
512	Хуримтлагдсан үр дүн	2,169,591,076.11	2,050,945,817.96
51210	Өмнөх үеийн үр дүн	2,169,591,076.11	2,169,591,076.11
51220	Тайлант үеийн үр дүн	-	(118,645,258.15)

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	788,025,066.60	788,025,066.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,573,502,678.79	4,454,842,420.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,010,328,824.00	1,205,817,540.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,972,950.00	80,153,240.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,972,950.00	80,153,240.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,972,950.00	80,153,240.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,190,150.00	23,500,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,782,800.00	56,652,440.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	986,355,874.00	1,125,664,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	336,552,900.00	418,850,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	336,552,900.00	418,850,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,844,000.00	89,914,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,970,000.00	89,914,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,874,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	424,876,814.00	616,899,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	424,876,814.00	616,899,300.00
1330	Төсвийн захирагчдаас	210,082,160.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,422,100.00	-
133003	Хөрөнгийн	2,660,060.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	947,363,790.23	1,309,308,998.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	947,363,790.23	1,309,308,998.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	931,167,066.08	1,259,037,563.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,330,578.85	282,775,288.10
210101	Үндсэн цалин	259,172,101.85	221,489,936.00
210102	Нэмэгдэл	4,158,477.00	32,125,799.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,957,000.00
210104	Урамшуулал	-	9,202,553.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,419,393.00	34,981,657.00
210201	Тэтгэврийн даатгал	24,395,610.32	26,781,173.21
210202	Тэтгэмжийн даатгал	2,661,214.60	2,172,818.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,081,991.64	1,710,063.37
210204	Ажилгүйдлийн даатгал	480,079.70	392,509.22
210205	Эрүүл мэндийн даатгал	4,800,496.74	3,925,093.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	422,476,814.00	576,772,768.00
210301	Гэрэл, цахилгаан	17,940,592.00	28,852,267.00

210302	Түлш, халаалт	378,108,700.00	509,318,404.00
210303	Цэвэр, бохир ус	26,427,522.00	38,602,097.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,213,690.00	36,507,967.00
210401	Бичиг хэрэг	480,000.00	1,477,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,210,000.00	2,858,270.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	760,790.00	1,198,843.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,331,600.00	572,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	569,100.00	2,927,340.00
210408	Бараа материал ақталсны зардал	6,862,200.00	27,473,714.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,515,000.00	2,400,000.00
210604	Урсгал засвар	1,515,000.00	2,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	921,000.00	1,895,000.00
210702	Дотоод албан томилолт	921,000.00	1,895,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,199,264.00	1,536,789.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,199,264.00	470,328.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	210,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	117,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	88,000.00
210807	Газрын төлбөр	-	219,461.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	192,091,326.23	322,168,094.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,698,200.00	164,162,210.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,680,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	155,393,126.23	156,325,884.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,196,724.15	50,271,434.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,075,000.00	28,350,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	26,885,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,075,000.00	1,465,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,121,724.15	21,921,034.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,121,724.15	21,921,034.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	62,965,033.77	(103,491,458.23)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	121,408.44	15,153,799.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	121,408.44	7,603,799.92
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	7,550,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(121,408.44)	(15,153,799.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	62,843,625.33	(118,645,258.15)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,007,005,964.00	1,149,165,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,190,150.00	23,500,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,190,150.00	23,500,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,190,150.00	23,500,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,190,150.00	23,500,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	996,815,814.00	1,125,664,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	336,552,900.00	418,850,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	336,552,900.00	418,850,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,964,000.00	89,914,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,970,000.00	89,914,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,994,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	424,876,814.00	616,899,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	424,876,814.00	616,899,300.00
1330	Төсвийн захирагчдаас	207,422,100.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,422,100.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	786,463,864.00	1,117,407,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	786,463,864.00	1,117,407,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	770,267,139.85	1,067,136,165.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,330,578.85	282,790,288.10
210101	Үндсэн цалин	259,172,101.85	221,504,936.00
210102	Нэмэгдэл	4,158,477.00	32,125,799.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,957,000.00
210104	Урамшуулал	-	9,202,553.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,419,393.00	34,981,657.00
210201	Тэтгэврийн даатгал	24,395,610.32	26,781,173.21
210202	Тэтгэмжийн даатгал	2,661,214.60	2,172,818.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,081,991.64	1,710,063.37
210204	Ажилгүйдлийн даатгал	480,079.70	392,509.22
210205	Эрүүл мэндийн даатгал	4,800,496.74	3,925,093.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	422,476,814.00	576,772,768.00
210301	Гэрэл, цахилгаан	17,940,592.00	28,852,267.00
210302	Түлш, халаалт	378,108,700.00	509,318,404.00
210303	Цэвэр, бохир ус	26,427,522.00	38,602,097.00

2104	Хангамж, бараа материалын зардал	7,143,700.00	9,443,253.00
210401	Бичиг хэрэг	480,000.00	1,372,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,210,000.00	2,858,270.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	915,000.00	1,297,843.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,815,100.00	572,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	723,600.00	3,342,340.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,604,000.00	2,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	204,000.00	-
210604	Урсгал засвар	2,400,000.00	2,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	921,000.00	1,895,000.00
210702	Дотоод албан томилолт	921,000.00	1,895,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,530,454.00	2,310,489.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,530,454.00	1,244,028.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	210,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	117,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	88,000.00
210807	Газрын төлбөр	-	219,461.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,841,200.00	156,542,710.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,841,200.00	154,862,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,680,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,196,724.15	50,271,434.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,075,000.00	28,350,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	26,885,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,075,000.00	1,465,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,121,724.15	21,921,034.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,121,724.15	21,921,034.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	220,542,100.00	31,757,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,120,000.00	31,757,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,120,000.00	31,757,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,120,000.00	31,757,500.00
222001	Тоног төхөөрөмж	13,120,000.00	31,757,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(13,120,000.00)	(31,757,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	207,422,100.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,397,448,304.08	788,025,066.60	2,169,591,076.11		6,355,064,446.79
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,397,448,304.08	788,025,066.60	2,169,591,076.11	-	6,355,064,446.79
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(67,707,817.92)		(67,707,817.92)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,397,448,304.08	788,025,066.60	2,101,883,258.19	-	6,287,356,628.87
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,397,448,304.08	788,025,066.60	2,101,883,258.19	-	6,287,356,628.87
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,397,448,304.08	788,025,066.60	2,101,883,258.19	-	6,287,356,628.87
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(118,645,258.15)		(118,645,258.15)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,397,448,304.08	788,025,066.60	1,983,238,000.04	-	6,168,711,370.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,039,749,600.00	1,015,779,563.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1039749600.00	1015779563.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1011399200.00	987429163.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280483800.00	266794658.10
210101	Үндсэн цалин	213311400.00	205509306.00
210102	Нэмэгдэл	33037600.00	32125799.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18900000.00	19957000.00
210104	Урамшуулал	15234800.00	9202553.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33947500.00	33133285.00
210201	Тэтгэврийн даатгал	23103900.00	24932801.21
210202	Тэтгэмжийн даатгал	2718100.00	2172818.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2174500.00	1710063.37
210204	Ажилгүйдлийн даатгал	541000.00	392509.22
210205	Эрүүл мэндийн даатгал	541000.00	3925093.05

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	585992500.00	576772768.00
210301	Гэрэл, цахилгаан	28674000.00	28852267.00
210302	Түлш, халаалт	509318500.00	509318404.00
210303	Цэвэр, бохир ус	48000000.00	38602097.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9611600.00	9443253.00
210401	Бичиг хэрэг	1372800.00	1372800.00
210402	Тээвэр, шатахуун	2860000.00	2858270.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,464,300.00	1,297,843.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,000.00	572,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,342,500.00	3,342,340.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,400,000.00	2,400,000.00
210604	Урсгал засвар	2,400,000.00	2,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,895,000.00	1,895,000.00
210702	Дотоод албан томилолт	1,895,000.00	1,895,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,378,500.00	2,310,489.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,245,000.00	1,244,028.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	210,000.00	210,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	142,500.00	117,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	250,000.00	219,461.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,690,300.00	94,679,710.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,010,300.00	92,999,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,680,000.00	1,680,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,350,400.00	28,350,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,350,400.00	28,350,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,885,400.00	26,885,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,465,000.00	1,465,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,044,021,300.00	1,037,424,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	427,122,700.00	418,850,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	427,122,700.00	418,850,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	616,898,600.00	616,899,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	616,898,600.00	616,899,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,674,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,674,500.00

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		
		1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		
		30.00	23.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	20.00	13.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,964,000.00	111,464,502.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,844,000.00	79,707,002.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,844,000.00	79,707,002.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	15,995,630.00
210101	Үндсэн цалин	-	15,995,630.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,848,372.00
210201	Тэтгэврийн даатгал	-	1,848,372.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,844,000.00	61,863,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,844,000.00	61,863,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,120,000.00	31,757,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,120,000.00	31,757,500.00
222001	Тоног төхөөрөмж	13,120,000.00	31,757,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,964,000.00	89,914,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	27,964,000.00	89,914,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,970,000.00	89,914,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,994,000.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Биеийн тамир спортын газар нь нийтийн биеийн тамир, спортын сургалт дасгалжуулалтын үр өгөөжийг нэмэгдүүлж, үндэсний болон спортын төрлүүдээр хүүхэд залуучуудад бие бялдрын өв тэгш хүмүүжлийн цогц чадамжийг ойлгох, сайржуулах чиг үүргийг хэрэгжүүлэг байна. Чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, биеийн тамир чийрэгжүүлэлт арга хэмжээг өргөн хүрээтэй үр дүнтэй зохион байгуулах
- Хувь хүн ,хамт олон, хэсэг бүлгээрээ биеийн тамир, спортоор хичээллэх сэтгэл зүйн болоод материаллаг орчин нөхцөлийн бүрдүүлэх
- Хүн амын эрүүл мэндийн чийрэгжүүлэх үйлсэд хамт олны оролцоог дээшлүүлж идэвх санаачилгыг дэмжин өрнүүлэх замаар хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх арга хэмжээг идэвхжүүлэх
- Сургалт дасгалжуулалт шинжлэх ухааны үндэслэлтэй үр дүнтэй зохион байгуулах
- Орон нутгаа орчин үеийн болоод үндэсний спортын төрлүүдээс түлхүү хөгжүүлэх бодлого барьж спортыг ур чадвар сайтай тамирчдыг бүс, улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнүүдэд амжилт гаргах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Биеийн тамир спортын газар нь Биеийн тамир спортын тухай хууль, Төсвийн тухай хууль болон түүнтэй уялдуулан гарсан бусад хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд спорт цогцолбор, Б заал, усан спорт сургалтын төв зэрэг 3 объектод тэмцээн уралдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Биеийн тамир спортын газар нь дотоод аудит, аудиторын чиг үүргийн тусгайлан хариуцсан алба, ажилтан байхгүй бөгөөд аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2 жил дутам 1 удаа хяналт шалгалт хийгддэг байна.

Аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд санхүүгийн хяналт шалгалт хийгдсэн бөгөөд хяналт шалгалтаар нийт 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах/ шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Биеийн тамир спортын газар нь Булган аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хэрэглэгдэг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн/нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Биеийн тамир спортын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 118,645.3 мянган төгрөгөөр буюу 1.86 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мян.төг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	84,683.60	52,930.10	-31,753.50
Үндсэн хөрөнгө	6,270,395.80	6,183,489.00	-86,906.80
Нийт хөрөнгө	6,355,079.4	6,236,419.1	-118,660.30
Өр төлбөр	15.0	0	-15.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,355,064.4	6,236,419.10	-118,645.30
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,355,064.4	6,236,419.10	-118,645.30

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын данс өмнөх оны үзүүлэлтээс 31,753.5 мянган төгрөгөөр буюу 37.4 хувиар буурсан нь тайлант онд өөрийн хөрөнгөөр нийт 36,522.0 мянган төгрөгийг бараа материалыг худалдан авсан, аймгийн Засаг даргын тамгын газраас 11,387.0 мянган аж ахуй материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, нийт 44,638.8 мянган төгрөгийг зарцуулж, аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/399 тоот захирамжаар 7,550.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Спортын дунд сургуульд үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн, Төсвийн шууд захирагчийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны А/53 дугаар тушаалаар 20,642.9 мянган төгрөгийн аж ахуй материал, 572.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/86 дугаар тушаалаар 4,524.2 мянган төгрөгийн аж ахуй материал, 626.6 мянган төгрөгийн эм боох материал, 190.0 мянган төгрөгийн барилга засварын материал акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс өмнөх оноос 86,906.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өөрийн 31,757.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, аймгийн Засаг даргын тамгын газраас 22,340.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн, Төсвийн захирагчийн 2022 оны 6 дугаар сарын 19-ны А/54 дүгээр тушаалаар 22925.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн, Төсвийн захирагчийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны А/53 дугаар тушаал, 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/86 дугаар тушаалаар нийт 78,127.1 мянган төгрөгийн тоног

төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж, Спортын дунд сургуульд 7,540.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 808,603.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 585,624.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,394,227.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжих зардлыг 350,072.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 128,124.4 мянган төгрөгөөр бууруулж, 1,035,900.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан төсвийг бууруулж хянасантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,035,341.9 мянган төгрөгөөр баталж тодотгол ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 418,850.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 616,899.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжихээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсөв орон нутгийн төсвөөр 1,035,750.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 23,500.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн, 14,750.6 мянган төгрөгийг улсын төсөвт, 6,894.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,018,105.0 мянган төгрөг буюу хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 21,921,034.90 төгрөгийн цалинг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Улс, Орон нутгийн төсөв	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
					Зөрүү	Биелэлт
1	71701	Спортын арга хэмжээ				
2	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	243,119.5	240,182.01	2,937.49	98
3	80102	Туслах үйл ажиллагааны зардал	54,871	43,068	11,802.56	78
4	80305	Биеин тамир уралдаан тэмцээний зардал	60,873	60,862	10.59	99
5	80802	Ажил олгочоос олгох тэтгэмж	28,350	28,350	-	100
6	82106	Нийтийн биеийн тамир	31,637	31,637	-	100
Нийт дүн			418,850,800	404,100,157.10	14,750,642.90	
	71701	Спортын арга хэмжээ			0.00	
1	80111	Тогтмол зардал	584,392,500	577,498,106	6,894,394.00	98
2	80112	Нийтлэг үйлчилгээ	32,506,800	32506800	0.00	100

3	Үндсэн үйл ажиллагааны орлого	24,055,800	23,779,802	275,998.00	98
Нийт дүн		640,955,100	633,784,708	7,170,392.00	
Нийт бүгд дүн		1,059,805,900	1,037,884,865	21,921,034.90	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын А\32 тоот захирамжаар өсвөрийн шигшээ багийн 2 хүний дасгалжуулагчийн цалин болох 15,855.0, А\55 тоот захирамжаар 5,970.0, А\203 тоот захирамжаар 5,600.0, А\357 тоот захирамжаар 5,127.0, А\749 тоот захирамжаар 2,000.0, Засаг даргын тамгын газраас баяр наадмын зардлыг санхүүжүүлэхээр 8,987.2, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг санхүүжүүлэхээр 13,800.0 нийт 111,740.5 мянган төгрөгийн орлогыг хүлээн авч өсвөрийн шигшээ багийн 2 хүний дасгалжуулагчийн цалинд 15,579.0, бөхийн сар шинийн барилдаанд 5,970.0, бүх ард түмний наадмын зардалд 5,6000.0, үндэсний спортын наадмын зардалд 5,127.0, аймгийн баяр наадмын зардалд 8,987.2, тоног төхөөрөмжийн зардалд 13,800.0 нийт 111,740.5 мянган төгрөгийг зарцуулж 275,9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биеийн тамир спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Биеийн тамир спортын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 01/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 1,035,002.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,525.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Биеийн тамир спортын газар нь тогтмол зардлуудыг хэмнэх ажлыг зохион байлгуулсны үр дүнд өмнөх оноос гэрэл цахилгааны зардлыг 61 хувь, цэвэр бохир усны зардлыг 46 хувь, түлш халаалтын зардлыг 35 хувиар тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймгийн биеийн тамир спортын газар нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 13 удаагийн нийт 997,668.2 мянган төгрөгийн орлогын мэдээлэл, 12

удаагийн 538,252.6 мянган төгрөгийн зарлагын мэдээлэл, 6.4.8-д заасан 57 удаагийн 52,888.8 мянган төгрөгийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 зугаар зүйлийн 6.4-д “Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 41,990.8 мянган төгрөгийн зөрчилд 183.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 41,807.8 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэнг бүрэн хэрэгжүүлэн хариуг 2022 оны 06 дугаар сарын 10 өдрийн А/23 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	183.0	1	183.0	100
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	3	41,807.8	3	41,807.8	100
Нийт дүн	4	41,990.8	4	41,990.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бүтэц орон тоонд батлаагүй нийт 2 гэрээт ажилчны цалингийн зардалд 15,579.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвөөс зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.2, 15.2.6-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалттай нийцэхгүй байгааг дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлэх.

Аймгийн ИТХ-ийн 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17 дугаар тоот тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам” -ыг үндэслэн төсвийн шууд захирагчийн тушаалаар хөрөнгө акталж байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-тай нийцэхгүй байгааг холбогдох байгууллагад уламжлан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар 5,425.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 303.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,121.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Шатахууны зардлыг тооцож олгохдоо автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 303.8 мянган төгрөгийг илүү тооцон олгож Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Халаалтын зардлаас Е-баримтаар баталгаажуулаагүй гүйлгээг хийсэн Татварын ерөнхий хуулийн 28.5-; “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар бүрэн баталгаажуулаагүй байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар бүрэн баталгаажуулан хийсэн Татварын ерөнхий хуулийн 28.5 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

2. Үндсэн хөрөнгө, бараа материал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг тооцоо бодсон баримтаар баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2, 71.2, 73.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2, 71.2, 73.2 бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	/мянган төгрөгөөр/		Зөвлөмж
				Үүнээс		
				Залруулсан	Залруулаагүй	

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

	Тоо	Дүн										
Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг тооцоо бодсон баримтаар баталгаажуулаагүй	1		1						1		1	
Дүн	1		1						1		1	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар бүрэн баталгаажуулаагүй	1	5,121.5					1	5,121.5				
Шатахууны зардлыг тооцож олгохдоо автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй	1	303.8	1	303.8								
Дүн	2	5,425.3	1	303.8			1	5,121.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс	1						1	

ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй.								
Дүн	1						1	
Нийт дүн	1						1	



БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2023 оны 06 дугаар сарын 15

Дугаар 01/34

Булган сум

10660248

БТА-2023/153/НА-СТА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Булган аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахууны зардлыг тооцож олгоходоо автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 303,823.52 /гурван зуун гурван мянга найман зуун хорин гурав/ төгрөгийг илүү тооцон олгож Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 190 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх холбогдох тушаалыг зөрчин зарцуулсан 303,823.52 /Гурван зуун гурван мянга найман зуун хорин гурав/ төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Биеийн тамир, спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Батхишиг, нягтлан бодогч Н.Болормаа нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

АХЛАХ АУДИТОР

Г.НАМЧИНСҮРЭН



6317144798
ГНОА0048 3190269

² Булган аймаг Булган сум 5-р баг аймгийн ЗДТГ-ийн байр 4 давхар 403 тоот өрөө, утас-70342716

006050103